



## Мэдээний тойм:

- “Монголын хөрөнгийн бирж” ТӨХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн шинэ гишүүд томилогдлоо
- Бүртгэлтэй компаниудын мэдээ
- Сүүлийн 2 долоо хоногийн арилжааны мэдээ
- Санхүүгийн зохицуулах хорооны 2007 оны 156 дугаар тогтоолд өөрчлөлт орлоо
- 2013 оны 1-р сарын арилжааны статистик мэдээ

## “Монголын хөрөнгийн бирж” ТӨХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн шинэ гишүүд томилогдлоо

Төрийн өмчийн хорооны 2012 оны 11 дүгээр сарын 29-ний өдрийн 554 тоот тогтоол болон 2013 оны 1 дүгээр сарын 24-ний өдрийн 23 тоот тогтоолоор “Монголын хөрөнгийн бирж” ТӨХК-ийн төлөөлөн удирдах зөвлөлийн өмнөх гишүүдийг чөлөөлж, шинэ гишүүдийг дараах бүрэлдэхүүнтэйгээр томиллоо. Үүнд:

ТУЗ-ийн даргаар Төрийн өмчийн хорооны Бүтцийн өөрчлөлтийн бодлогыг хэрэгжүүлэх газрын дарга М.Батгэрэл, гишүүдээр Санхүүгийн зохицуулах хорооны Дэд дарга Б.Даажамба, Эдийн засгийн хөгжлийн яамны Хөгжлийн бодлого, стратеги төлөвлөлтийн газрын Нэгдсэн төлөвлөлтийн хэлтсийн дарга Г.Батхүрэл, Эрчим хүчний яамны Хуулийн хэлтсийн дарга Б.Баяр, Уул уурхайн яамны Төрийн захиргааны удирдлагын газрын Гадаад хамтын ажиллагааны хэлтсийн дарга А.Хүрэлбат, Үйлдвэр, хөдөө аж ахуйн яамны Хүнд үйлдвэрийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга М.Баянмөнх, хараат бус гишүүдээр “МАК” компанийн Нийгмийн хариуцлага тогтвортой хөгжлийн газрын захирал Д.Болормаа, “Либерти Партнерс” ХХК-ийн Гүйцэтгэх захирал Ч.Ганбат, болон “ЭмДиЭс энд Ассошейтс” хуулийн фирмийн Ерөнхий партнер Ж.Майзориг нар сонгогдлоо.


## “Глобал Монголия Холдинг” ХК-ийн үнэт цаасны бүртгэлд өөрчлөлт орлоо

“Монголын хөрөнгийн бирж” ТӨХК-ийн “Үнэт цаасны бүртгэлийн журам”-ын 50.3, 57 дахь заалт, “Глобал монголия холдинг” ХК-аас ирүүлсэн хүсэлтийг үндэслэн 2013 оны 02 дугаар сарын 06-ны өдрийн “Монголын хөрөнгийн бирж” ТӨХК-ийн гүйцэтгэх захирлын тушаалаар “Глобал монголия холдинг” ХК-ийн оноосон нэрийг “Глобал монголия холдингс” болгон үнэт цаасны бүртгэлд өөрчлөлт орууллаа.

## “Солонго Экспресс” ХК-ийн үнэт цаасны бүртгэлд өөрчлөлт орлоо

Санхүүгийн зохицуулах хорооны 2012 оны 9 дүгээр сарын 12-ны өдрийн 284 тоот тогтоол, “Монголын хөрөнгийн бирж” ТӨХК-ийн “Үнэт цаасны бүртгэлийн журам”-ын 50.1, 50.3, 57 дугаар зүйлийг тус тус үндэслэн 2013 оны 1 дүгээр сарын 31-ний өдрийн “Монголын хөрөнгийн бирж” ТӨХК-ийн гүйцэтгэх захирлын тушаалаар “Солонго экспресс” ХК-ийн нийт гаргасан 156,523 ширхэг энгийн хувьцааг 451,286 ширхэг энгийн хувьцаагаар нэмэгдүүлэн, нийт 607,809 ширхэг хувьцаатай болгож, компанийн оноосон нэрийг “Еврофё Азия” ХК болгон үнэт цаасны бүртгэлд өөрчлөлт орууллаа.

## TOP-20 индексийн үзүүлэлт



2013 оны 2 дугаар сарын 1-нээс 2013 оны 2 дугаар сарын 15-ны хооронд нийт 9 удаагийн арилжаа явагдаж, 60 компанийн 2.3 тэрбум төгрөгийн үнийн дүн бүхий 1.1 сая ширхэг хувьцаа арилжсан байна.

Тус хугацаанд хамгийн идэвхтэй арилжигдсан компани нь “Говь” ХК /976.9 сая.төг/, “Еврофё азия” ХК /812.9 сая.төг/ “Шарын гол” ХК /250.7 сая.төг/ байсан байна.

## Үнэт цаасны арилжааны мэдээ

### Хувьцааны арилжаа

2 дугаар сарын 1-нээс 2 дугаар сарын 15-ны хооронд:

Арилжаа явагдсан өдөр	9
Арилжигдсан ширхэг	1.1 сая
Арилжигдсан дүн	2.3 тэрбум төгрөг
Арилжигдсан компанийн тоо	60
Нийт хийгдсэн хэлцлийн тоо	510
Өдрийн дундаж	255.6 сая төгрөг

### Хамгийн их өсөлттэй:

Олоо /OLL/ **+32.35%**  
Уран барилга /UBA/ **+30.65%**  
Зоос гоёл /ZOO/ **+30.42%**

### бууралттай:

Баян-алдар /MIK/ **-15.00%**  
Монгол савхи /UYN/ **-13.75%**  
Бэрх уул /BEU/ **-12.70%**

### Зах зээлийн үнэлгээ:

1,747,2 тэрбум.төг  
1.25 тэрбум ам.доллар

### TOP-20 индексийн өөрчлөлт:

17596.24 / **-0.41%**

2013 оны 2 сарын 15  
(10-р хэвлэл)



# МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ Э-СОНИН

## Санхүүгийн зохицуулах хорооны 2007 оны 156 дугаар тогтоолд өөрчлөлт орлоо

Санхүүгийн зохицуулах хороо /СЗХ/-ны 2013 оны 2 дугаар сарын 6-ны өдрийн 40 дүгээр тогтоолоор СЗХ-ны 2007 оны 10 дугаар сарын 30-ны өдрийн “Үнэт цаасны зах зээлд оролцогч тусгай зөвшөөрөл бүхий этгээдээс төвлөрүүлэх зохицуулалтын үйлчилгээний хөлсний хэмжээг шинэчлэн тогтоох тухай” 156 дугаар тогтоолын хавсралтын хүснэгтийн 1 дэх мөрийг дор дурьдсан агуулгаар өөрчлөн найруулсан байна.

№	Зохицуулалтын үйлчилгээ		Зохицуулалтын үйлчилгээний хөлс		
	зохицуулалтын үйлчилгээний хөлсөд хамаарах тусгай зөвшөөрөл	эрхэлж буй үйл ажиллагаа	арилжаа, гүйлгээ хийгдсэн өдөр тутам /хувиар/	тухайн жил бүр /төгрөгөөр/	үйлчилгээ үзүүлсэн тухай бүр /төгрөгөөр/
1	1.1 Арилжаа эрхлэх	1. а/ Хувьцаа	Үнэт цаасны арилжааны гүйлгээнээс тусгай зөвшөөрөл бүхий мэргэжлийн байгууллагын олсон шимтгэлийн орлогын 10 хувь	-	-
	1.2 Төлбөр тооцоо /биржийн/	1. б/ Бусад үнэт цаас			
	1.3 Брокер	1. а/ Хувьцаа	1.а/ Хувьцааны арилжааны худалдах, худалдан авах хэлцэл тус бүрийн үнийн дүнгийн 0,13 хувь  1.б/ Хувьцаанаас бусад үнэт цаасны арилжааны гүйлгээнээс олсон шимтгэлийн орлогын 10 хувь	-	-
	1.4 Дилер	2. б/ Бусад үнэт цаас			

### 2013 оны 1-р сарын арилжааны статистик мэдээ

Арилжаа явагдсан өдөр	23
Үнэт цаас нь бүртгэгдсэн нийт компанийн тоо	329
Төрийн өмчийн /100%/	23
Төрийн өмчийн оролцоотой	29
Хувийн өмчийн	277
Үнэт цаас нь арилжигдсан компанийн тоо	96
Нийт бүртгэлтэй үнэт цаасны тоо /ширхэг/	4,779,746,863
Төрийн өмчид /ширхэг/	2,088,231,046
Олон нийтэд /ширхэг/	2,691,515,817
Зах зээлийн нийт үнэлгээ /төгрөг/	1,762,239,110,129
/ам доллар/	1,265,467,276
Нийт арилжааны үнийн дүн /төгрөг/	4,254,594,802
Хувьцаа	4,254,594,802
Засгийн газрын бонд	0
Компанийн бонд	0
Нийт арилжигдсан үнэт цаасны тоо /ширхэг/	8,722,803
Хувьцаа	8,722,803
Засгийн газрын бонд	0
Компанийн бонд	0
Нийт хийгдсэн хэлцлийн тоо	1690
Өдрийн дундаж /хувьцааны арилжаагаар/	
Үнийн дүн /төгрөг/	184,982,383
Арилжигдсан ширхэг	379,252
Хэлцлийн тоо	73
Топ-20 Индекс	
Дундаж	18,038.17
Хамгийн их	18,301.93
Хамгийн бага	17,691.12
Хаалт	17,691.12
Төвлөрсөн хадгаламжинд нээгдсэн данс	2,755
Аж ахуйн нэгж	21
Иргэн	2,734
Төгрөг /ам. доллартай харьцах ханш/	1,392.56